



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР" ТӨХХК-ИЙН 2021
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/62/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Аудитор: М.Лхагвасүрэн
Утас: 261740 Цахим хаяг: lhkagvasurenm@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн Си Эс Ай Аудит ХХК.
Захирал: М.Сэвжидмаа
Утас: 7001981 Цахим хаяг: csi_sevjee@yahoo.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	10
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	10
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	10
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
5.1 Шилэн дансны мэдээлэл	14
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
8. Аудитын илрүүлэлт	15
8.1 Залруулсан алдаа	15
8.2 Төлбөрийн акт	15
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
МГТБҮ	Монголын газрын тос боловсруулах үйлдвэр
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ЦТҮС ТӨХК	Цахилгаан дулаан үндэсний сүлжээ төрийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компани
УУХҮЯ	Уул уурхай хүнд үйлдвэрийн яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022-03-15 № 07/600

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт 6,557.5 сая төгрөгийн алдаа, зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа эсвэл нийтээрээ материаллаг боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 "нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1 "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.4 "аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр", 14.4.5.-т "бүх орлого" 14.4.6 "бүх зардал", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцээгүй санхүүгийн тайлангийн үнэлгээ, эрх ба үүрэг, тохиолдсон байх, үнэн, зөв, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно:

Нийт 67,456.9 сая төгрөгийн зардал төлөвлөж гүйцэтгэлээр 13.4 сая төгрөгийн орлого олж, 41,957.6 сая төгрөг зарцуулснаас урсгал үйл ажиллагааны зардалд 23,536.9 сая төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр 27,381.4 сая төгрөгийн зардал гарч тайлант жилийн нийт алдагдал 27,367.8 сая төгрөг байна.

Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу 2021 оны хөрөнгө оруулалтаар нийт 43,920.0 сая төгрөгийг 19 ажил төлөвлөж 14,576.3 сая төгрөгийн 14 худалдан авалт хийж 33.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн тайланд 16 зорилтын хүрээнд 91 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	7,870,219,103.99	4,849,374,592.78
1.1.2	Дансны авлага	2,821,200.0	8,459,545.00
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	93,907,675.44	189,432,365.09
1.1.4	Бусад авлага	32,259,167.57	49,775,388.32
1.1.6	Бараа материал	33,879,559.05	41,397,375.13
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	4,963,032,427.11	4,819,277,173.23
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	12,996,119,133.16	9,957,716,439.57
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	148,026,473,890.94	155,930,856,991.09
1.2.2	Биет бус хөрөнгө	6,687,495,436.90	9,544,047,173.65
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,000,000.0	1,000,000.0
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	154,715,918,418.74	165,719,673,410.94
1.2.11	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	167,712,037,551.90	175,677,389,850.51
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	7,194,425,048.38	5,440,585,893.31
2.1.1.2	Цалингийн өглөг	164,332.78	310,574.31
2.1.1.3	НДШ-ийн өглөг	1,150,020,108.20	66,838,010.38
2.1.1.3	Зээлийн хүү	26,051,014,964.71	
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	34,395,624,454.00	4,551,138,717.82
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	140,717,699,360.04	158,744,844,710.70
2.1.2.2	Урт хугацаат зээлийн хүү		43,486,671,160.89
2.1.2.2	Урт хугацаат бусад өр төлбөр		956,595,760.18
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	140,717,699,360.04	203,188,111,631.77
2.2	Өр төлбөрийн нийт дүн		
2.3.1	Төрийн өмч	10,000,000.00	10,000,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	6,677,600,000.00	9,384,783,200.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(14,088,886,262.21)	(41,456,643,699.08)
2.3.11	Эздийн өмчийн дүн	(7,401,286,262.21)	(32,061,860,499.08)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	167,712,037,551.90	175,677,389,850.51

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)		
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)		
4	Хүүгийн орлого	2,696,558.23	
5	Бусад орлого	1,660,437.45	13,398,883.24
6	Ерөнхий ба удирдлагын зардал	3,163,123,635.80	7,174,501,505.32
7	Санхүүгийн зардал	7,082,078,967.85	13,876,949,549.48
8	Бусад зардал	69,034,196.82	42,079,843.23
9	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(34,454,300.72)	(24,537,961.93)
10	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		(6,263,087,460.15)
11	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(10,344,334,105.51)	(27,367,757,436.87)
12	Орлогын татварын зардал	269,655.83	0.00
13	Татварын дараах ашиг (алдагдал)	(10,344,603,761.34)	(27,367,757,436.87)
14	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(10,344,603,761.34)	(27,367,757,436.87)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	10,000,000.00	6,677,600,000.00	3,744,282,500.87	2,943,317,499.13
Залруулсан үлдэгдэл	10,000,000.00	6,677,600,000.00	3,744,282,500.87	2,943,317,499.13
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			10,344,603,761.34	10,344,603,761.34
Дахин үнэлгээ хэрэгжилтийн дүн		6,677,600,000.00		6,677,600,000.00
2020 оны 12 дугаар сарын 31-ээрх үлдэгдэл	10,000,000.00	6,677,600,000.00	14,088,886,262.21	7,401,286,262.21
Залруулсан үлдэгдэл	10,000,000.00	6,677,600,000.00	14,088,886,262.21	7,401,286,262.21
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			27,367,757,436.87	27,367,757,436.87
Дахин үнэлгээ хэрэгжилтийн дүн		(2,707,183.00)		(2,707,183.00)
2021 оны 12 сарын 31	10,000,000.00	9,384,783,200.00	41,456,643,699.08	32,061,860,499.08

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,625,071,263.19	12,636,616.97
1.1.4	Буцаан авсан албан татвар	5,711,547.00	
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,619,359,716.19	12,636,616.97
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,564,834,418.68	7,379,313,540.44
1.2.1	Ажиллагсад төлсөн	1,603,632,426.75	2,036,505,872.49
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	439,837,753.89	590,035,355.52
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	46,502,221.83	99,710,023.00
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	80,491,947.37	21,014,545.45
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	221,716,223.69	1,472,947,750.96
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	3,158,258.00	
1.2.9	Бусад мөнгөн зарлага	2,169,495,587.15	3,159,099,993.02
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,939,763,155.49)	(7,366,676,923.47)
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,696,558.23	
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	2,696,558.23	
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	16,029,051,972.00	13,681,303,008.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	305,931,274.00	259,659,028.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,666,300.00	2,605,900.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	15,716,454,398.00	13,419,038,080.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	1,000,000.00	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(16,026,355,413.77)	(13,681,303,008.00)
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	20,911,153,603.87	18,027,166,707.21
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	20,901,639,016.81	18,027,145,350.66
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	9,514,587.06	21,356.55
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,004,927.96	31,286.95
3.2.5	Валютын ханшийн тэгштгэлийн алдагдал	5,004,927.96	31,286.95
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	20,906,148,675.91	18,027,135,420.26
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,940,030,106.65	(3,020,844,511.21)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,930,188,997.34	7,870,219,103.99
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,870,219,103.99	4,849,374,592.78

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/ мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт зардал	м.төг	10,314,236.6	23,536,894.1	27,381,384.7	(3,844,490.6)	116.3
	Ерөнхий ба удирдлагын зардал	м.төг	3,125,191.5	8,881,094.1	3,653,382.9	5,227,711.2	41.1
	Санхүүгийн зардал /зээлийн хүүгийн зардал/	м.төг	7,082,079.0	14,505,800.0	13,876,949.6	628,850.4	95.7
	Элэгдлийн зардал	м.төг	106,966.3	150,000.0	3,587,964.8	(3,437,964.8)	2,392.0
2	Бусад зардал	м.төг	-	-	6,263,087.5	(6,263,087.5)	
3	Татварын өмнөх ашиг	м.төг	(10,344,334.1)	(22,984,894.1)	(27,367,757.4)	4,382,863.3	119.1
4	Цэвэр ашиг/алдагдал/	м.төг	(10,344,603.7)	(22,984,894.1)	(27,367,757.4)	4,382,863.3	119.
5	Нийт ажиллагсдын тоо	хүн	77	150	85	65	56.7
6	Нийт цалингийн сан	м.төг	1,808,957.1	5,371,542.0	1,853,719.1	3,517,822.9	34.5
7	Нэг ажилтны дундаж цалин	м.төг	1,957.7	2,984.2	1,817.4	1.166.8	60.9
8	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	м.төг	1	1	1	1	100.0
9	Хөрөнгө оруулалт, зөвлөх үйлчилгээ	м.төг	17,997,586.8	43,920,033.8	14,576,269.3	29,343,764.5	33.2
10	Нийт авлага	м.төг	128,690.6	-	5,020,514.8	(5,020,514.8)	
	Дансны болон бусад авлага	м.төг	3,334.4	-	4,783,562.4	(4,783,562.4)	
	Барьцааны авлага	м.төг	31,710.0	-	47,520.0	(47,520.0)	
	НДШ, татварын авлага	м.төг	93,646.2	-	189,432.4	(189,432.4)	
11	Нийт өглөг	м.төг	175,113,315.9	187,342,117.5	207,739,250.3	(20,397,132.8)	110.9
	Дансны өглөг	м.төг	991,512.8	-	1,159,641.1	(1,159,641.1)	
	НДШ, татварын өглөг	м.төг	1,150,020.1	-	66,838.0	(66,838.0)	
	Барьцааны өглөг	м.төг	6,203,068.6	3,842,068.6	4,281,255.3	(439,186.7)	
	Урт хугацааны хүүгийн өглөг	м.төг	26,051,015.0	42,782,349.5	43,486,671.2	(704,321.7)	101,6
	Банкны урт хугацаат зээл	м.төг	140,717,699.4	140,717,699.4	158,744,844.7	(18,027,145.3)	112.8

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бөжөн аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагын шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгсөн.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 20-оос 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Си Эс Ай Аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Чулуунбат аудитор С.Тогтохсүрэн, Б.Отгончимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал М.Сэвжидмаа хэрэгжүүлсэн

"Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК нь 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/50 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Засгийн газрын хэрэг эрхлэх газар дотоод аудитын хорооноос 2019-2020 оны үйл ажиллагааны өнөөгийн байдалд аудит хийж 2021 оны 05 дугаар сарын 25-нд дүгнэлт гаргасан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

"Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 10,348.6 сая төгрөгийн 1 хувиар буюу 103.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд, төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани гэсэн статустай, 100 хувь төрийн өмчит компани байна.

Улсын их хурлаас 2017 оны 5 сарын 31-ний өдөр Монгол Улсын засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импортын банк хоорондын 1.0 тэрбум ам долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийг баталсан бөгөөд Засгийн газрын 2017 оны 59 дүгээр тогтоолоор дээрх хэлэлцээрийн хүрээнд "Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төслийг хэрэгжүүлэхээр баталжээ.

Тус компани нь захиргааны газар, санхүү эдийн засгийн газар, гэрээ эрх зүй, гадаад харилцааны газар, дэд бүтэц тээвэр ложистикийн газар, газрын тосны хайгуул ашиглалтын газар, дамжуулах хоолой хариуцсан газар гэсэн 6 газар 9 хэлтэстэй үйл ажиллагаа явуулж, төслийг Хөгжлийн банкны жилийн 11.89 хувийн хүүтэй зээл 158,744.8 сая төгрөг, Эрдэнэс-Монгол ХХК-аас 956.6 сая төгрөгийн зээл авч санхүүжсэн, зээлийн хүү 43,486.7 сая төгрөг, нийт 202,231.5 сая төгрөгийн зээлийн өр үүссэн, зээлийн эргэн төлөлт 2023 онд хийгдэж эхэлнэ.

Компанийн дүрмийн 8.1-т "Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчийн хурал байх ба хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам түүнийг төлөөлж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд хэрэгжүүлэх" гэж заасны дагуу бүрэн эрхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд хэрэгжүүлж байна.

Тус компани нь энэхүү чухал аж үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх ажлыг нарийвчилсан техник эдийн засгийн үндэслэл боловсруулахаас эхлэн ерөнхий ба нарийвчилсан инженерийн зураг төсөл, худалдан авалт, барилга угсралтын ажлыг дуусгаж, үйлдвэрийг ашиглалтад оруулах хүртэлх бүх шатны ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэгч ба зөвлөх компаниудыг сонгон шалгаруулан, мэдээ, мэдээлэл, судалгааны материалаар ханган, тэдэнтэй нягт хамтран ажиллаж, хяналт тавин, ажил үүргийг цаг хугацаанд нь төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх үүргийг хүлээдэг.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 508 дугаар тогтоолоор 17.5 км хүнд даацын тусгай зориулалтын авто зам, 27 км салаа төмөр зам, 18.2 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц (110/35/10 кв) нийт 122.9 тэрбум төгрөгийн хөрөнгө ашиглалтад авсан. 2021 онд уг төмөр замаар 106,262 тн ачаа тээвэрлэсэн байна.

ТӨБЗГ-ын 2021 оны 10 сарын 19-ний өдрийн 491 дүгээр тогтоолоор ЦТҮС ТӨХК-д 6,399.6 сая төгрөгийн 18.2 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц (110/35/10 кв)-ыг балансаас балансад шилжүүлэн хүлээлгэн өгсөн байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын төвөөс 1.5 км-т байрлах ба тус бүр 46-55 м2 бүхий нийт 550 айлын орон сууцны 10 барилга угсралтын ажлын эхний ээлжийг ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн "Технологийн бус байгууламжийн Инженерчлэл-худалдан авалт-барилга угсралтын ажил ЕРС-1"-ийн ерөнхий гүйцэтгэгчээр шалгарсан" Жэй Эм Си Прожектс Индиа" компанитай гэрээ байгуулсан ажиллаж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны 14/06 дугаар зөвлөмжид "Стратегийн чухал ач холбогдолтой газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдэд түшиглэн байгуулах" Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.70-д" Газрын тосны олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэн, газрын тосны үйлдвэр байгуулна гэж тусгагдсан байна.

Засгийн газрын 2017 оны 92 дугаар тогтоолоор "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийг хэрэгжүүлэх, өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий 100 хувь төрийн өмчийн компани байгуулахаар шийдвэрлэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 108 дугаар тогтоол Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК байгуулагдсан.

Засгийн газрын 2018 оны 323 дугаар тогтоолоор Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Уул Уурхай, хүнд үйлдвэрийн яамыг, компанийн дүрмийг холбогдох хууль тогтоомжийн дагуу баталж, мөрдүүлэхийг Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдад даалгасны дагуу Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд 2018 оны А/259 дүгээр тушаалаар Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн дүрмийг баталсан байна. Үүнд:

- Газрын тос боловсруулах үйлдвэр барьж ашиглалтад оруулах;
- Үйлдвэрийг барьж байгуулах явцад болон ашиглалтад оруулахын өмнө шаардлагатай мэргэжлийн ажиллах хүчийг гадаад улсад болон дотооддоо сургаж бэлтгэх;
- Стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж борлуулах;
- Үйлдвэрийг түүхий эдээр хангах;
- Түүхий тос дамжуулах хоолой барьж байгуулах;
- Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д газрын тостой холбогдсон үйл ажиллагааг явуулах;
- Компанийн дүрмийн 4.2.3-4.2.17-д заасан үйл ажиллагаа явуулахаар заасан

Тус компани нь Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/166 дугаар тушаалаар газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх 371 тоот тусгай зөвшөөрөл авсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд "Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй, 5-т "төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өмчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах" гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг хувьцаа эзэмшигчийн хурлаар сонгох гэсэн заалтыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам түүнийг төлөөлж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд хэрэгжүүлэх, 9 гишүүнтэй тэдгээрийн 3 нь хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүнийг нэг удаа улируулан сонгож болно" гэсэн заалтын мөрдөх.

Монгол Улсын Засгийн газрын "2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.4.10-т "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно." гэж заасан байна.

Монгол Улсын засгийн газрын “төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.2-т “шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоо нэмэгдүүлэхгүй байх өндөр насны тэтгэвэрт тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардал хэмнэх” гэсэн заалтыг зөрчиж 2021 оны төсвийг ТУЗ-ийн 2021 оны 02 сарын 18-ны өдрийн 04 дүгээр тогтоолын 01 дүгээр хавсралтаар компанийн бүтэц орон тооны хязгаар 140 орон тоогоор өмнөх оноос 55 орон тоо илүү баталсан байна. 2 дугаар хавсралтаар компанийн 2021 оны эдийн засгийн зорилтод түвшинг 23,536.9 сая төгрөгөөр өмнөх оноос 13,603.6 сая төгрөгөөр илүү төлөвлөсөн, ТУЗ-ийн цалинг 21.5 сая төгрөгөөр илүү олгосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэхгүй байна. / албан шаардлага өгсөн/

Тус байгууллага нь төрийн өмчийн хөрөнгөнд хяналт тавих, зардал бууруулах арга хэмжээ авч ажиллаагүй 2021 онд төмөр замын ашиглалтын төлбөр аваагүй байна. /орлогыг нөхөн тооцож төсөвт төвлөрүүлэх акт тогтоосон/

Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй холбоотой гарсан халаалтын зардлыг санхүүжүүлж зээл нэмэгдүүлсэн, 2019 онд тендерт шалгарсан компанитай гэрээ байгуулж урьдчилгааг зээл хэлбэрээр олгосон, дараагийн ажлын ажлын гүйцэтгэлээс 25 хувийг суутгаж төлөлт хийж байгаагаас шалтгаалж 4,772.1 сая төгрөгийн 4 байгууллагад өгсөн урьдчилгаанд ногдох 582.6 сая зээлийн хүүг өөрсдөө /МГТБҮ/ төлөхөөр тооцон зардалд бичсэн байна./зөрчил арилгах албан шаардлага өгсөн/

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль
- Монгол улсын Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 2021 оны 43 дугаар тогтоол

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн боловч авлага, өглөгийн бүртгэлд ангилал зөрүү тайлагнасан.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	7,870.2	4,849.4	(3020.8)
Авлага	129.0	247.6	118.6
Бараа материал	33.9	41.4	7.5
Урьдчилж төлсөн зардал	4,963.0	4,819.3	(143.7)
Үндсэн хөрөнгө	148,026.5	155,390.9	7364.4
Биет бус хөрөнгө	6,687.5	9,544.0	2,856.5
Урт хугацаат хөрөнгө оруулалт	1.0	1.0	
Хойшлогдсон татварын өглөг	0.9	783.8	782.9
Нийт хөрөнгийн дүн	167,712.0	175,677.4	7,965.4
Богино хугацаат өглөг	34,395.6	4,551.2	(29,844.4)

Урт хугацаат өглөг	140,717.7	203,188.1	62,470.4
Эздийн өмч	(7,401.3)	(32,061.9)	(24,660.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	167,712.0	175,677.4	7,965.4

Өмнөх оны үзүүлэлтүүдээс дараах дансуудын үлдэгдэлд материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Банк дахь харилцах дансны үлдэгдэл 4,849.4 сая төгрөг өмнөх оноос 3,020.8 сая төгрөгөөр буурсан.
- Авлагын дансны үлдэгдэл 247.6 сая төгрөг болж өмнөх оноос 118.6 сая төгрөгөөр өссөн нь НӨАТ-ын 117.9 сая төгрөг, ХХОАТ-ын 0.7 сая төгрөгийн илүү төлөлтөөс шалтгаалсан;
- Бараа материал дансны үлдэгдэл 41.4 сая төгрөг болж өмнөх оноос 7.5 сая төгрөгөөр өссөн нь хангамжийн материалын худалдан авалтаас шалтгаалсан;
- Урьдчилж төлсөн тооцоо дансны үлдэгдэл 4,819.3 сая төгрөг өмнөх оноос 143.7 сая төгрөгөөр буурсан нь эргэн төлөлтөөс шалтгаалсан;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 155,390.9 сая төгрөг болж өмнөх оноос 7,364.4 сая төгрөгөөр өссөн нь гаалийн татвар 344.1 сая, худалдаж авсан 398.0 сая төгрөг буюу нийт 742.1 сая төгрөгөөр тус нэмэгдэж ТӨБЗГ-ын шийдвэрээр үнэ төлбөргүй балансаас балансад шилжүүлсэн агаарын цахилгаан шугам 6,399.6 сая төгрөг, акталсан 2.7 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус буурснаас шалтгаалсан байна.
- Биет бус хөрөнгө 2,856.5 сая төгрөгөөр өссөн нь газар эзэмших, ашиглах эрхийг дахин үнэлснээс шалтгаалсан;
- Дуусаагүй барилга дансны үлдэгдэл нь 40,961.4 сая төгрөг өмнөх оноос 16,472.1 сая төгрөгөөр өссөн нь барилгын гүйцэтгэлээс шалтгаалсан;
- Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 4,551.2 сая төгрөг өмнөх оноос 29,844.4 сая төгрөгөөр буурсан нь урт хугацаат зээлийн хүүгийн өглөг 26,051.0 сая төгрөг залруулж, дансны өглөг 2,710.5 сая төгрөг, татварын өглөг 1,083.2 сая төгрөгөөр тус тус буурсан холбоотой;
- Урт хугацаат зээлийн үлдэгдэл 203,188.1 сая төгрөг өмнөх оноос 162,470.4 сая төгрөгөөр өссөн нь Хөгжлийн банкнаас авсан зээлийн санхүүжилт, богино хугацаат өглөгөөс урт хугацаат зээлд залруулсан 44,443.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зардлыг хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээг нь зээлийн зардлыг зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна.

Зардлыг өмнөх онтой харьцуулахад нийт зардал 17,032.5 сая төгрөгөөр өссөн нь ерөнхий удирдлагын зардал 4,011.4 сая төгрөг, санхүүгийн зардал 6,794.9 сая төгрөг, бусад зардал 6,226.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалжээ.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн байгууллагын зорилтот түвшинг боловсруулж, ТУЗ-өөр батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Уул Уурхай хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны А/55 дугаар тушаалаар Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингээр ерөнхий ба удирдлагын зардал 23,536.9 сая төгрөг, хөрөнгө

оруулалтын зардалд 43,920.0 сая төгрөг нийт 67,456.9 сая төгрөгийн зардал төлөвлөж батлагдсан байна.

Гүйцэтгэлээр ерөнхий ба удирдлагын зардалд 27,381.4 сая төгрөгийн зардал гарч, 3,844.5 сая төгрөг буюу 16.3 хувиар хэтэрүүлсэн. Хөрөнгө оруулалтын зардалд 14,576.3 сая төгрөг зарцуулж 29,343.8 сая төгрөг буюу 66.8 хувь хэмнэсэн байна.

Нийт үйл ажиллагааны орлого 13.4 сая төгрөг. Энэ нь тендерийн материал худалдан авах, банкны хүү, валютын ханшийн бодит ашиг орсонтой холбоотой байна.

Нийт зардал 27,381.2 сая төгрөг тайлагнаснаас удирдлагын зардал 7,174.5 сая төгрөг, өмнөх оноос 4,011.4 сая төгрөгөөр хэтэрсэн нь элэгдлийн зардал 3,438.0 сая төгрөгөөр нэмэгдсэн, зочид хүлээн авах зардал 7.3 сая, мэдээллийн технологийн үйлчилгээний зардал 13.1 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн.

Санхүүгийн зардал 13,876.9 сая төгрөг өмнөх оноос 6,794.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь бусдад шилжүүлсэн хөрөнгийн зээлийн хүүгийн зардлаас шалтгаалсан байна.

Бусад зардал 42.1 сая төгрөг зарцуулж өмнөх оноос 26.9 сая төгрөгөөр буурсан;

Гадаад валютын ханшийн гарз 24.6 сая төгрөг өмнөх оноос 9.9 сая төгрөгөөр буурсан;

Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз 6,263.1 сая төгрөг тайлагнасан балансаас балансад хассан үндсэн хөрөнгөөс шалтгаалж тайлант жилд 27,367.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК байгууллага нь тайлант онд нийт 24,175.0 сая төгрөгийн 175 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 263.8 сая төгрөгийн 13 мэдээллийг ил тод байршуулаагүй, 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж үнэн зөв, бодитой, иж бүрэн, тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлж байх зөвлөмж өгөв.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд зарим мэдээллийг байршуулаагүй, хугацаа хоцроосон нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 13,627.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад алдаа зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 741.3 сая төгрөгийн 5 зөрчил илэрсэн үүнээс 4.5 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 79.9 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 656.9 сая төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгснөөс төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	1	4.5	1	4.5			100.0
Албан шаардлага	1	79.9	1	79.9			100.0
Зөвлөмж	3	656.9	3	656.9			100.0
Нийт дүн	5	741.3	5	741.3			100.0

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дуусаагүй үйлдвэрлэл, ажлын гүйцэтгэл, авлага, зорилтот түвшинг шалгах аар шийдвэрлэв.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 51,185.6 сая төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс 44,628.1 сая төгрөгийн 2 алдааг залруулж 1,741.0 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 4,816.5 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 6,557.5 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 103.5 сая төгрөгийн ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 44,628.1 сая төгрөгийн 2 алдааг залрууллаа. Үүнд:

1. Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт байрлах ашиглах болон эзэмших эрхийн газрын 34 ширхэг гэрчилгээ эзэмшдэгээс 27 гэрчилгээ 888.9 га газар үнэлгээгүй байсныг дахин үнэлгээ хийлгэсэн.
2. Санхүүгийн тайланд урт хугацаат өр төлбөр зээлийн хүү 43,486.7 сая төгрөг, Эрдэнэс Монгол ХХК-аас авсан 956.6 сая төгрөгийг зээлийг буруу ангилан богино хугацаат өр төлбөрийн дансанд тус тус залруулсан.

8.2 Төлбөрийн акт

1. Албан томилолтоор ажилласан 13 ажилтанд томилолтын мөнгөтэй давхардуулан илүү цагийн хөлс 8.1 сая төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн, зөв, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь Албан томилолтоор ажилласан ажилтнуудад давхардуулан олгосон илүү цагийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн Хонгорын овоо өртөө хүртэлх 27 км төмөр замаар Болд төмөр ерөө гол ХХК-ийн 297 вагон 21,984 тн, МТЛ ХХК-ийн 659 вагон 44,232.3 тн ачаа, Цахиурт овоо ХХК-ийн 545 вагон 37,66.5 тн ачаа тээвэрлэсэн бөгөөд тус төмөр замыг ашигласан дээрх байгууллагуудаас Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/154 тушаалын дагуу суурь бүтцийн ашиглалтын 1,732,9 сая төгрөгийн зам ашиглалтын төлбөр аваагүй алдаа зөрчил илэрсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 "нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" 14.4.1 "аж ахуйн бүх ажил, гүйлгээ" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн, зөв, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь Төмөр замыг ашигласан дээрх байгууллагуудаас Зам тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/154 тушаалын дагуу суурь бүтцийн ашиглалтын зардал 1,732.9 сая төгрөгийг төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

8.3 Албан шаардлага

1.Төлөөлөн удирдах зөвлөл нь тус байгууллагын техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин, орон тоог баталж өгөхдөө өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлаагүй, төслийн үе шаттай уялдуулаагүй, зардлын норм, норматив баримтлаагүй, хянагдаггүйгээс их хэмжээний төсөв баталж төлөөлөн удирдах зөвлөлд гадаад томилолтын зардал 21,6 сая төгрөг баталсан байна.

/Төлөөлөн удирдах зөвлөл нь тус байгууллагын техник эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин, орон тоог баталж өгөхдөө өмнөх оны гүйцэтгэлээс 73 орон тоогоор илүү баталсан нь тайлант оны гүйцэтгэлээр 65 орон тоо дутуу ажилласан, үйл ажиллагааны зардлыг өмнөх оны гүйцэтгэлээс 13,603.6 сая төгрөгөөр илүү/,

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 11 "Төрийн өмчийн төлөөлөгч нь төлөөлөн удирдах зөвлөлтэй тухайн хуулийн этгээдийн хэтийн төлөвлөгөөг тохиролцож, түүний хэрэгжилтийг хянаж, дүгнэхээс бусад хэлбэрээр өдөр тутмын удирдлагын үйл ажиллагаанд оролцохгүй." гэж заасныг иж бүрэн байх, үнэн зөв байх, бодитой байх гэсэн батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлөөлөн удирдах зөвлөл нь зорилтот түвшинг норм, норматив үндэслэх өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулж, хууль эрх зүйн хүрээнд батлах, түүнд хяналт тавих.

2. Тус байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 04 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг батлахдаа гишүүдийн цалинг 1,2 сая төгрөгөөр тогтоосноос 9 гишүүнд нийт 22.8 сая төгрөгийн цалин илүү олгосон алдаа зөрчил гаргасан байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн 3.7. Энэ журмын 3.6-д заасан цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12-т "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно." заалтуудтай нийцэхгүй иж бүрэн байх, үнэн зөв байх, бодитой байх гэсэн батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдэд илүү олгосон цалинг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох

3. Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК нь төслийг зээлээр санхүүжүүлдэг бөгөөд гэрээт байгууллага, туслан гүйцэтгэгчдэд урьдчилж төлсөн тооцооны авлага 4,772.1 төгрөг

байгаа нь зээлийн хүүг 582.6 төгрөг нэмэгдүүлж, зээлийг үр ашиггүй зарцуулж, алдагдал өсгөсөн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 “нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” 14.4.1 “аж ахуйн бүх ажил, гүйлгээ” 14.4.2 “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” 20 дугаар зүйлийн 20.2.5 “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*”; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчин хэрэгжүүлж ажиллаагүй, хэмжилт, үнэн зөв, тохиолдсон байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК нь төслийн ажлын гэрээ байгуулж ажиллаж байгаа аж ахуй нэгж байгууллагад урьдчилж төлбөр тооцоог хийхгүй гэрээний дагуу ажил үйлчилгээг үзүүлэх, төсвийг үр ашигтай зарцуулах, авлагыг үүсгэхгүй байх

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК	АХГ-2022/62/НА-СТА-ТӨА	ТУЗ-ийн 2021 оны 02 сарын 18-ны өдрийн 04 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар ТУЗ-ийн төсийг батлахдаа ТУЗ-ийн гишүүдийн цалинг 1.2 сая төгрөгөөр тогтоосноос 9 хүнд 22.8 сая төгрөг илүү олгосон байна.	ТУЗ -ийн гишүүдэд илүү олгосон цалинг төлүүлэх төлбөрийн акт тогтоох.	1	22,811.8					1	22,811.8				
2	Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК	АХГ-2022/62/НА-СТА-ТӨА	Албан томилолтоор ажилласан 13 албан хаагчдад 4 хоногийн томилолт олгож хагас бүтэн сайнд ажилласан илүү цагийг 8.1 сая төгрөг олгосон байна	Албан томилолтоор ажилласан ажилтанд давхардуулан олгосон илүү цагийн хөлсийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох	1	8,107.0			1	8,107.0						
3	Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК	АХГ-2022/62/НА-СТА-ТӨА	Төлөөлөн удирдах зөвлөл нь ТУЗ-ийн гадаад томилолтын зардал 21.5 сая төгрөг баталсан байна	Төлөөлөн удирдах зөвлөл нь зардлыг батлахдаа хууль эрх зүйн актыг норм норматив мөрдөх	1	21,550.0					1	21,550.0				
4	Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК	АХГ-2022/62/НА-СТА-ТӨА	Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт	Газар ашиглах болон эзэмших эрхийн газрын 34 ширхэг гэрчилгээ эзэмшдэгээс 27	1	184,815.2	1	184,815.2								

			байрлах ашиглах болон эзэмших эрхийн газрын 34 ширхэг гэрчилгээ эзэмшдэгээс 27 гэрчилгээ 888.9 га газар үнэлгээгүй байна.	гэрчилгээ 888.9 га газар үнэлгээгүй байсныг дахин үнэлгээ хийлгэж залруулсан														
5	Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК	АХГ-2022/62/НА-СТА-ТӨА	Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн Хонгорын овоо өртөө хүртэлх 27 км төмөр замаар тээвэр хийсэн 3 компаниас 1,732.9 сая төгрөгийн ашиглалтын зардал аваагүй байна.	Зам тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/154 тушаалын дагуу суурь бүтцийн ашиглалтын тооцоог хийж 1,732.9 сая төгрөгийг дээрх байгууллагаар төлүүлэхээр шийдвэрлэлээ.	1	1,732,900.7					1	1,732,900.7						
6	Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК	АХГ-2022/62/НА-СТА-ТӨА	Газрын тос боловсруулах үйлдвэр нь төслийг зээлээр санхүүжүүлж байгаа бөгөөд гэрээт байгууллага, туслан гүйцэтгэгч нараас авах авлага 4,772.1 сая төгрөг байгаа нь зээлийг үр ашиггүй зарцуулж зээлийн хүүгийн алдагдал нэмэгдүүлж байна.	Төслийн ажлын гэрээ байгуулж ажиллаж байгаа аж ахуй нэгж байгууллага урьдчилж төлбөр тооцоог хийхгүй гэрээний дагуу ажил үйлчилгээг үзүүлэх, төсвийг үр ашигтай зарцуулах, авлагыг үүсгэхгүй байх	1	4,772,100.0					1	4,772,100.0						
7	Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК	АХГ-2022/62/НА-СТА-ТӨА	Санхүүгийн тайланд урт хугацаат өр төлбөрийг ангилал зөрүүлж богино хугацаа өр төлбөрийн дансанд зээлийн хүү 43,486.7 сая төгрөг, Эрдэнэс Монгол ХХК-аас авсан 956,595.8	Өр төлбөрийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу зөв ангилж бүртгэх	1	44,443,267.0	1	44,443,267.0										

			мянган төгрөгийг зээлийг тус тус бүртгэсэн байна.														
ДҮН					7	51,185,551.7	2	44,628,082.2	3	1,741,007.7	2	4,816,461.8					
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																	
1	Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК	АХГ-2022/62/НА-СТА-ТӨА	Тайлант онд нийт 24,175.0 сая төгрөгийн 175 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 263.8 сая төгрөгийн 13 мэдээллийг ил тод байршуулаагүй, 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах	1	263,820.0										1	263,820.0
1	ДҮН				1	263,820.0										1	263,820.0
	НИЙТ ДҮН				8	51,449,371.7	2	44,628,082.2	3	1,741,007.7	2	4,816,461.8				1	263,820.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 08 дугаар сарын 15 № 129/А0150053
АХГ-2022/65/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан томилолтоор ажилласан 13 ажилтанд томилолтын мөнгөтэй давхардуулан илүү цагийн хөлс 8,107,500.00 төгрөг олгосон байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн, зөв, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Илүү олгосон цалин 8,107,500.0 /найман сая нэг зуун долоо мянга таван зуун/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, ерөнхий нягтлан бодогч Б.Чинтуяа нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР
СИ ЭС АЙ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

М.СЭВЖИДМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 130/А.0150053
АХГ-2022/65/НХ-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-т заасны дагуу Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн Хонгорын овоо өртөө хүртэлх 27 км төмөр замаар Болд төмөр ерөө гол ХХК-ийн 297 вагон 21,984 тн, МТЛ ХХК-ийн 659 вагон 44,232.5 тн ачаа, Цахиурт овоо ХХК-ийн 545 вагон 37,66.5 тн ачаа тээвэрлэсэн бөгөөд тус төмөр замыг ашигласан дээрх байгууллагуудаас Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/154 тушаалын дагуу суурь бүтцийн ашиглалтын 1,732,900,704.00 төгрөгийн зам ашиглалтын төлбөр аваагүй алдаа зөрчил илэрсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 “нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” 14.4.1 “аж ахуйн бүх ажил, гүйлгээ” Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн, зөв, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хураах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК, төлбөрийн гүйлгээний утгад төмөр зам ашиглалтын төлбөр 1,732,900,704.00 /нэг тэрбум долоон зуун гучин хоёр сая есөн зуун мянга долоон зуун дөрвөн / төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, ерөнхий нягтлан бодогч Б.Чинтуяа нарт хариуцуулав

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР
СИ ЭС АЙ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
М.СЭВЖИДМАА

9006109

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойрог-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264330

0001090302



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 547/А.0150053

Улаанбаатар хот

АХГ-2022/62/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөл нь тус байгууллагын техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин, орон тоог баталж өгөхдөө өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлаагүй, төслийн үе шаттай уялдуулаагүй, зардлын норм, норматив баримтлаагүй, хянадаггүйгээс их хэмжээний төсөв баталж төлөөлөн удирдах зөвлөлд гадаад томилолтын зардал 21,550,000.00 төгрөг баталсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 11 "Төрийн өмчийн төлөөлөгч нь төлөөлөн удирдах зөвлөлтэй тухайн хуулийн этгээдийн хэтийн төлөвлөгөөг тохиролцож, түүний хэрэгжилтийг хянаж дүгнэхээс бусад хэлбэрээр өдөр тутмын удирдлагын үйл ажиллагаанд оролдохгүй" гэж заасныг зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хууль тогтоомжийн хүрээнд ажиллах гарсан алдаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг гүйцэтгэх захирагч Д.Алтанцэцэг, ерөнхий нягтлан бодогч Б.Чинтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

АУДИТЫН ХОЁРДОГТААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ЭНХДАЛАЙ

СИ ЭС АЙ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

М.СЭВЖИДМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-26230

0019120396

eg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-222.Docx

0001081424



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 548/А0150053
АХГ-2022/65/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-т заасны дагуу Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК нь төслийг зээлээр санхүүжүүлж бөгөөд гэрээт байгууллага, туслан гүйцэтгэгчдэд урьдчилж төлсөн тооцооны аллага 4,772,099,978.00 төгрөг байгаа нь зээлийн хүүг 582,601,832.50 төгрөг нэмэгдүүлж, зээлийг үр ашиггүй зарцуулж, алдагдал өсгөсөн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 "нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" 14.4.1 "аж ахуйн бүх ажил, гүйлгээ" 14.4.2 "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчин хэрэгжүүлж ажиллаагүй, хэмжилт, үнэн зөв, тохиолдсон байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Урьдчилж төлсөн тооцоог барагдуулах, зээлийн хүүг тооцох байгууллагыг хохиролгүй болгох, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, ерөнхий нягтлан бодогч Б.Чинтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР  Д.ЭНХДАЛАЙ

СИ ЭС АЙ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ  М.СЭВЖИДМАА

9006109
9019120396



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 549/А0150053
АХГ-2022/62/МА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-т заасны дагуу Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 04 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг батлахдаа гишүүдийн цалинг 1,200,000.00 төгрөгөөр тогтоосноос 9 гишүүнд нийт 22,811,868.00 төгрөгийн цалин илүү олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн 3.7 "Энэ журмын 3.6-д заасан цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны гүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна". Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12 "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй нь үнэн, зөв, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлснээс ихгүй баталж өгөх албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, ерөнхий нягтлан бодогч Б.Чинтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮГЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

СИ ЭС АЙ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

М.СЭВЖИДМАА

